МЭДЭЭ · 2021 оны 4-р сарын 27

"ШИЙДВЭРЛЭЛТ-2021" АЯН ЗОХИОН БАЙГУУЛЖ, ДҮНГЭЭ ГАРГАЖЭЭ



Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газраас Цагдаагийн хэлтэс, тасагтай хамтран гэмт хэрэг үйлдсэн хүн нь тогтоогдоогүй хэрэг бүртгэлтийн хэргүүдийг шийдвэрлэх, эрэн сурвалжлагдаж буй этгээд, эд зүйлсийг олж тогтоох зорилгоор "Шийдвэрлэлт-2021" аяныг 1 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл гурван сарын хугацаанд зохион байгуулж, дүнгээ гаргажээ.

Нэгдсэн аяны хүрээнд нийт 47 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол 42 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн үр дүн гарсан байна.

Тус аянд бусдыгаа манлайлж ажилласан прокуророор хяналтын прокурор В.Төгсбаяр, мөрдөгчөөр Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Диваажигмэд нар шалгарчээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2866